



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 10 сарын 05 өдөр

Дугаар А/548

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1-ийн "а", Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах тухай тогтоолын 3 дугаар хавсралтын 4.19 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ховд аймгийн түүх соёлын хөшөө дурсгалын сувинер 142 ширхэгийг хийлгэх зардалд зориулан 7 100 000 төгрөг /долоон сая нэг зуун мянга/-ийг зарцуулсугай.

2. Дээрхи төсөл арга хэмжээний зардлыг орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2021 онд хэрэгжүүлэх, хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээний жагсаалтын 4.19-д тусгагдсан "Гурван сэнхэр төвтэй таван од аялал жуулчлалын хөтөлбөр"-өөс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/ нарт зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Т.Жаргалсайхан/-д даалгасугай.



ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ